

Sika® Leveling Mortar®

Цементэн суурьтай шалны тэгшилгээний хольц

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® Leveling Mortar® нь үйлчилгээний болон ахуйн хэрэглээний зориулалттай барилгын шалны тэгшилгээнд зориулагдсан дан бүрэлдэхүүнт, бэлэн хольц бүтээгдэхүүн юм.

Хэрэглээ:

5-9 мм-ийн зузаантай тэгшилгээ бүхий дараах хийцэд хэрэглэгдэнэ

- Винил хавтангууд
- Хивс, хивсэнцэр
- Спортын модон шалнууд
- Паркет шал
- Шалны бэлэн хийц бүхий системүүд
- Дээврийн мембран

Бүтээгдэхүүний давуу талууд

- Тогтвортой чанар бүхий бэлэн хольц
- Холиход хялбар
- Урсамтгай чанар маш өндөр, өөрөө тэгширдэг
- 5 – 9 мм-ийн зузаанд хэрэглэхэд тохиромжтой
- Гараар болон насос ашиглах боломжтой
- 18 цагийн дараа дээгүүр нь явж болно
- Хоргүй ба зэвэрдэггүй
- Хлорид болон төмөр агуулаагүй
- Доргилт болон цохилтын хүчид тэсвэртэй

Техникийн мэдээллүүд

Өнгө / Хэлбэр

Бетоны саарал өнгө бүхий бэлэн хольц

Дүүргэгчийн хэмжээ

Хамгийн ихдээ 2 мм

Нягт

нунтаг бүтээгдэхүүний нягт ~ 1,75 кг/л
шингэн зуурмагын нягт ~ 2,10 – 2,15 кг/л

Хольцын харьцаа

Жигд урсамтгай шинж чанар бүхий зуурмагт:
25 кг нунтаг бүтээгдэхүүнийг 4,5 – 5 л устай хольно

Нээлттэй байх хугацаа (+30°C хэмд)

Хамгийн багадаа 40 минут

Construction

Sika®

Гүйцэтгэлийн үеийн орчны ба гадаргуун температур	+25°C болон түүнээс бага хэмд зуурмагийн бэхжилтийн хугацаа болон бат бэх удааширч болзошгүй
Зарцуулалт	1 мм-ийн зузаанд ойролцоогоор 2,1 кг/м ²
Хадгалах хугацаа / Хадгалалт	Хуурай сэрүүн орчинд сав баглаа боодол бүрэн бүтэн тохиолдолд үйлдвэрлэснээс хойш 6 сарын хугацаанд хадгална.
Сав баглаа боодол	25 кг-ийн давхар цаасан ууттай байна
Хэрэглэх заавар	
Гадаргууг бэлдэх	<p>Гадаргуу нь бат бөх байж, элдэв бохирдол тос тосоолоос ангид цэвэр байх ёстой. Тэгшилгээний ажлыг хийхээс хэдэн цагийн өмнө гадаргууг усаар сайтар норгож өгөх шаардлагатай. Тэгшилгээний ажлыг гүйцэтгэхээс өмнө гадаргуу дээрх тогтсон усыг цэвэрлэж авна.</p> <p>Суурь түрхлэг: Зуурмагын барьцалтыг нэмэгдүүлэх үүднээс 1:1 – ийн харьцаатайгаар Sika Latex-ийг устай холин 100 – 200 гр/м² хэмжээтэйгээр гадаргуу дээр жигд түрхэхийн зөвлөж байна.</p> <p>Санамж: Суурь түрхлэгийг нойтон байхад нь Sika Leveling Mortar – ийн гүйцэтгэлийг хийнэ.</p>
Холих	<p>Sika Leveling Mortar –ийг холихдоо цэвэр хувинд автомат холигч ашиглана. Энгийн бетон зуурагчийг ашиглаж болохгүй. Хольцын харьцааны дагуу (25 кг-ийн нунтаг бүтээгдэхүүнд 4,6 – 4, 8 л) цэвэр хувиндаа эхлээд усаа хэмжиж хийгээд, дээрээс нь Sika Leveling Mortar бүтээгдэхүүний холих явцдаа аажим аажмаар хийж хольно. Холих хугацаа хамгийн багадаа 3 минут байна.</p> <p>Холих явцад зуурмагт агаар үүсгэхгүйн тулд автомат холигчийн хурд 500 грт-ээс хэтрүүлж болохгүй. Хольцын харьцаанд заасан хэмжээнээс илүү ус нэмж болохгүй.</p>
Хэрэглээ	<p>Хольцыг автомат холигчоор хольсоны дараа хусуур ашиглан алгуур хольж зуурмаг дахь агаарыг чөлөөлөх хэрэгтэй. Дараа нь зуурмагаа бетон гадаргуу дээр цутган шүдтэй нийвий болон самнуур ашиглан тэгшилгээний зузаанаа тохируулан тараана. Цутгасан тэгшилгээний зуурмагын агаарыг чөлөөлөх болон нимгэн хэсгийг тэгшлэх зорилгоор шүдтэй өнхрүүшийг ашиглана.</p>
Арчилгаа	<p>Барилгын дотор тэгшилгээ хийж байгаа тохиолдолд цутгалтын дараах арчилгаа шаардагдахгүй. Гэвч цутгалтын дараа тухайн өрөөний хаалга, цонхыг хааж бэхжилтийн үеийн чийгшил алдалтыг бууруулан, болзошгүй хагарлаас урьдчилан сэргийлэхийг зөвлөж байна.</p> <p>Хэрэв хавтгай дээвэр, сүүдрэвийн тэгшилгээнд хэрэглэх тохиолдолд цутгалтыг бороо, салхинаас хамгаалах хэрэгтэй.</p> <p>Нүүжилт ихтэй бетон гадаргуу нь Sika Leveling Mortar зуурмаг дахь усыг өөртөө шингээн авч, улмаар бэхжилтийн дараа гадаргуу дээр аалзны торны хэлбэлтэй мөр үүсгэж болзошгүй.</p>
Цэвэрлэгээ	Ажил дууссаны дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ усаар цэвэрлэнэ. Багаж дээр хатсан зуурмагыг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Гүйцэтгэлийн үед бээлий болон хамгаалалтын нүдний шил зүүгээрэй. Арьсанд хүрсэн тохиолдолд савантай усаар сайтар угаана. Нүд болон салслаг бүрхэвчид орсон тохиолдолд урсгал усаар сайтар зайлаад эмчийн тусламжийг авах шаардлагатай. Гүйцэтгэлийн орчин шаардлага хангасан агааржуулалтын системтэй байх шаардлагатай.

Бат бэхийн үр дүн (N/mm²)

	1 хоног	3 хоног	7 хоног	28 хоног
18%-ийн Ус	> 5	> 25	> 30	> 35

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

Sika (Thailand) Limited

Head Office
700/37 Moo 5, Bangpakong Industrial Park II,
Bangna-Trad KM.57, Tambol Klong Tamhru,
Muang District, Choburi, Thailand 20000

Tel: +66 3821 4270-85
Fax: +66 3821 4286
E-mail: sikathai@th.sika.com
www.sika.co.th

The Sika logo consists of the word "Sika" in a bold, yellow, sans-serif font, with a registered trademark symbol (®) to its upper right. The logo is set against a red triangular background that points downwards.